



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 17 өдөр


Дугаар 72

Сүхбаатар сум

Журам батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, “Хог хаягдлын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/ болон сумдын Засаг дарга нарт даалгасугай.
3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, үйл ажиллагааны журам батлах тухай” 2015 оны 68 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын  
2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн  
72 дугаар тогтоолын хавсралт

TTC7446 9055363

## “ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ”

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Аймгийн нутаг дэвсгэр дэх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2 Энэхүү журмыг аймаг, сум, багийн Засаг дарга нар нутаг дэвсгэртээ зохион байгуулж аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа, үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.

1.3 Энэхүү журамд дурьдагдсан “энгийн хог хаягдал”, “хог хаягдлыг ангилах”, “хог хаягдлыг цуглуулах”, “хог хаягдлыг дахин боловсруулах”, “хог хаягдлыг сэргээн ашиглах”, “хог хаягдлыг устгах”, “хог хаягдлыг булшлах” гэсэн нэр томъёонуудыг Хог хаягдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан утгаар ойлгоно.

1.4 “Энгийн хог хаягдлыг тээвэрлэх” гэж хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачин хог хаях зориулалтын цэг хүртэл, эсхүл энэ журмын 5.1-д заасны дагуу шалгарсан энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэн өгөх хүртэлх тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэлнэ.

### Хоёр. Оролцогч талуудын эрх, үүрэг

#### 2.1. Аймгийн Засаг даргын эрх, үүрэг

2.1.1 Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжих, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

2.1.2 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа аймгийн хэмжээнд зохион байгуулах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад дээрх үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

## 2.2 Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг

2.2.1. Сумын нутаг дэвсгэрт энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тариф болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоон баталж мөрдүүлэх;

2.2.2 Энэхүү журмын хэрэгжилтэд сум, орон нутгийн хэмжээнд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах;

## 2.3 Сумдын Засаг даргын эрх, үүрэг

2.3.1 Сумын нутаг дэвсгэрт энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох;

2.3.2 Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагын хариусан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох;

2.3.3 Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах;

2.3.4 Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулах, тэдгээрт олгох мөнгөн урамшууллыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулж, зарцуулалтад хяналт тавих;

2.3.5 Сумын нутаг дэвсгэрт хамаарах олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг хийхээр сонгон шалгарсан байгууллагаар гүйцэтгүүлэх;

2.3.6 Нийтийн эдэлбэр газарт ангилан ялгах хогийн савыг хүртээмжтэй тоогоор байрлуулах, айл өрхийг хог ангилан ялгах хогийн савтай болгох ажлыг зохион байгуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

2.3.7 Хог хаягдлыг төвлөрүүлэн устгах, булшлах цэг болон дахин боловсруулах, сэргээн ашиглах хог хаягдлыг түр хадгалах барилга, байгууламжийг бий болгох;

## 2.4 Багийн Засаг даргын эрх, үүрэг

2.4.1 Багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

2.4.2 Хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах;

2.4.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.4.4 Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;

2.4.5 Хог хаягдлын хууль тогтоомж, журмыг сурталчилан таниулж, хог хаягдлыг бууруулах, ангилах, цэвэрлэх талаар олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах

2.4.6 Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах талаар аливаа санал санаачилгыг дэмжин санал санаачлага гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулах, ажиллуулах;

## 2.5 Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх, үүрэг

2.5.1 Хог хаягдлын тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

2.5.2 Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;

2.5.3 Оршин суугаа нутаг дэвсгэртээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шаардлага хангасан хогийн савыг байршуулж, үүсгэсэн хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын хогийн сав болон цэгт хаях, хог тээвэрлэгч байгууллагын хуваарьт өдөр ачуулах эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

2.5.4 Хог хаягдлаа ангилан ялгах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавих, хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгчийг хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хяналт тавих эрх бүхий байгууллагад мэдэгдэх эрхтэй.

2.5.5 Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;

2.5.6 Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд идэвхитэй оролцно.

2.5.7 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлнө.

2.5.8 Төв суурин газарт хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон газраас бусад газарт ил задгай хаях, шатаахыг хориглоно.

2.5.9 Төв суурингаас алслагдсан /малчин/ айл өрх нь нутаглаж буй газрынхаа ойр орчмын хог хаягдлыг хариуцан цэвэрлэж байгаль орчинд халгүй, сөрөг нөлөөгүй хамгийн боломжит арга технологоор устгана.

2.5.10 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага худалдаа үйлчилгээ, өргөн хэрэглээнд цаасан болон даавуун уут, мөн 0,035 мм хүртэлх зузаантай гялгар уутыг хэрэглэнэ.

**Гурав. Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгчийг сонгон шалгаруулах, бүртгэх, гэрээг байгуулах, цуцлах**

3.1 Сумын Засаг дарга энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллана.

3.2 Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэхээр шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад бүртгүүлэн үйл ажиллагааг эрхлэнэ.

3.3 Энгийн хог хаягдлыг цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлага, хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтанд тавигдах шаардлагын талаар энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулах гэрээнд тусгана.

3.4 Сумын Засаг дарга энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгчийн гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх ба гэрээний биелэлт хангалтгүй гэж дүгнэгдвэл гэрээг цуцална.

3.4. Гэрээг цуцлах тохиолдолд сумын Засаг дарга хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгчид 14 хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ.

**Дөрөв. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа**

4.1 Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь сумын нутаг дэвсгэр дэх хог хаягдлыг бүрэн хариуцан ажиллаж хог хаягдлыг тээвэрлэх чиглэл, хуваарийг сумын Засаг даргаар батлуулж, мөрдөнө.

4.2 Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь хуваарийн дагуу ангилсан хог хаягдлыг зориулалт, битгүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

4.3 Хог хаягдлыг ангилан ялгасан тус бүрээр тээвэрлэлт хийж төвлөрсөн цэг эсхүл хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.

4.4 Хог хаягдал тээвэрлэх жолооч, ачигч, туслах ажилтан нар холбогдох сургалтад хамрагдсан байна.

4.5. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагааг давхар эрхэлж болно.

**Тав. Энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг сонгон шалгаруулах, бүртгэх, гэрээг байгуулах, цуцлах**

5.1 Аймгийн Засаг дарга энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллана.

5.2 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэхээр шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэн үйл ажиллагааг эрхэлнэ.

5.3 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь холбогдох хууль дүрэм журмыг удаа дараа зөрчсөн нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон эсхүл тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцална.

5.4 Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлал, зуслан, орон сууц, олон нийтийн бүс, усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хүн амын унд, ахуйн усан хангамжийн тэжээгдлийн мужийн дотор, ойн сангийн газар, хамгаалалтын бүсийн ой, хориотой зурвасын ой, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламж байгуулахыг хориглоно.

5.5 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь жил бүр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, удирдлагаар батлуулж ажиллана.

5.6 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагааны тайлан мэдээллийг улирал бүр аймгийн Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.7 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжийн ажилтан тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтад хамрагдаж, шалгалтанд тэнцсэн байна.

5.8 Энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах;

5.8.1 Энгийн хог хаягдлыг дараах байдлаар ашигласныг сэргээн ашиглах гэж үзнэ.

а/Хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж, эрчим хүч /цахилгаан, дулаан, халуун ус/ үйлдвэрлэх;

б/ Байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр, зөвшөөрсөн арга, технологиор хог хаягдлыг нэрэх, угаах, ариутгах, цэвэрлэх, сэргээх аргаар боловсруулж, эргүүлэн ашиглах чанарын шаардлага хангасан, эдийн засгийн хувьд ашигтай болгож хог хаягдлыг анхны хэлбэрт оруулах;

5.8.2 Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар нутаг, суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно.

а/ Хог хаягдал сэргээн ашиглах технологи нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, сэргээн ашиглсан бүтээгдэхүүн нь хүн, мал, амьтан, ургамалд хор хөнөөлгүй байна.

б/ Хог хаягдлыг сэргээн ашиглах байгууламж нь зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, мал, амьтан орохоос хамгаалсан хашаатай байна.

в/ Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагааны ажиллах хүч нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдан, хог хаягдал дахин сэргээх байгууламжийн зорилго, үр дүнг тодорхойлох чадвартай, техник технологийг бүрэн эзэмшсэн байна.

5.9 Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах;

5.9.1Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон хог хаягдал цуглуулах эрх бүхий этгээдээр дамжуулан цуглуулж болно.

5.9.2Дахин боловсруулах үйлдвэрээс гарсан шинэ бүтээгдэхүүн нь байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчинд аюулгүй хүний хэрэгцээ шаардлага стандартыг хангасан байна.

5.9.3 Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч нь хоёрдогч түүхий эд худалдаж авах цэг байгуулж болно.

5.10 Энгийн хог хаягдлыг устгах;

5.10.1 Энгийн хог хаягдлыг ландфилл аргаар булшлах, хими, биологийн аргаар устгах, зориулалтын байгууламжид шатаах, хог хаягдлыг халдвартгүйжүүлж, байгальд хоргуй болгож устгана.

5.10.2 Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа хийгдсэний дараа үлдсэн хог хаягдлыг энэ шаардлагын 5.8.1-д заасан аргын аль тохирохыг ашиглан хог хаягдлыг устгана.

5.10.3 Хог хаягдлыг зориулалтын аргаар устгахдаа булшлах аргыг аль болох ашиглахгүй байх.

5.11 Энгийн хог хаягдлыг булшлах;

5.11.1 Байгальд 5-10 жилд хоргуйгээр уусч алга болох хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөгдсөн ландфилл талбайд зориулалтын тоног төхөөрөмжөөр булшилна.

5.11.2 Хог хаягдлыг булшлах ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргуй нөхцлөөр, ландфилл аргаар хийгдэнэ.

5.11.3 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”-ын дагууаймгийн нутаг дэвсгэр энгийн хог хаягдал булшлах төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах харилцааг зохицуулна.

### Зургаа. Хүлээлгэх хариуцлага

6.1 Хог хаягдлын тухай хууль тогтоомж болон энэхүү журмыг зөрчигчдөд Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

ооо